



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 23

Хажуу шинэ үсэг

Сумын Засаг даргын үйл ажиллагааны  
хөтөлбөрийн явц, үр дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "Д" заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны хэрэгжилтийн явц, үр дүнг "хангалттай" гэж дүгнэсүгэй.

2. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэд хөтөлбөрийн жагсаалтыг гаргаж, жил бүрийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл, төлөвлөгөөнд тусган шаардлагатай төсөв хөрөнгийг сумын төсөвт суулган хэрэгжилтийг ханган явц, үр дүнг эхний хагас жилд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн, жилийн эцэст Төлөөлөгчдийн хуралд тайлагнахыг Засаг дарга /Б.Доржсүмбэр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

040020



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 24

Хажуу шинэ ус

Сумын 2018 оны үндсэн чиглэл  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "А" заалт, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл, төлөвлөгөөний хэрэгжилтийг "хангалттай" гэж үзсүгэй.

2. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл, төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3. Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хуралд хагас жилээр, төлөөлөгчдийн хуралдаанд жилийн эцсээр тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

040001



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 25

Хажуу шинэ үс

Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 /e/, /з/ заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Говь-Угтаал сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

1.1. Хөгжлийн төлөвлөгөөний баримт бичгийг сурталчилан таниулах, орон нутгийн иргэдийн газар, байгалийн нөөц эдэлбэрийн зүй ёсны эрхийг бүртгэн баталгаажуулахыг сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/-т даалгасугай.

2. Нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумын нийгэм, эдийн засгийн мастер төлөвлөгөө, сумын дахин төлөвлөлттэй уялдуулан орон нутгийн хөгжлийн хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж, үр дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж байхыг сумын Засаг даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, биелэлтийг тооцож ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нарт даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

• 040026



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 26

Хажуу шинэ үе

Сумын 2018 оны төсөв  
батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 64.1.2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2, Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 сарын 04-ны өдрийн 25 дугаар тогтоолыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Сумын 2018 оны төсөвт төвлөрүүлэх орлогын нэр төрөл, хэмжээг дор дурдсанаар баталсугай:

		/мянган төгрөг/
	<b>Сумын төсвийн орлого бүгд</b>	<b>1136911,3</b>
1	<b>Урсгал орлого</b>	<b>67170,4</b>
1.1.	<b>Татварын орлого</b>	<b>41383,4</b>
1.1.1.	Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	14128,5
1.1.2.	Хадгаламжийн хүүгийн орлого	20851,6
1.1.3.	Бууны албан татвар	1138,0
1.1.4.	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	1965,7
1.1.5.	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1383,1
	Хог хаягдлын үйлчилгээ	1916,5
1.2.	<b>Татварын бус орлого</b>	<b>25787,0</b>
1.2.2.	Хүү, торгуулийн орлого	7369,4
1.2.3.	Бусад орлого	18417,6
3.	<b>Тусламжийн орлого</b>	<b>892194,2</b>
3.1.	Санхүүгийн дэмжлэг	186677,5
3.2.	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	52447,6
3.3.	Тусгай зориулалтын шилжүүлэг	702366,7
3.4.	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000,0
3.5.	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1150,0
3.6.	Урьд оны үлдэгдлээс	

Хоёр. Сумын 2018 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

• 040028

д/д	ТЕЗ, түүний харьяа байгууллага	ДҮН /мянган төгрөг/
2.1.	Засаг даргын тамгын газар	1000.0
2.2	Соёлын төв	2000.0
2.3	Ерөнхий боловсролын сургууль	150.0
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>3150,0</b>

**Гурав.** Сумын 2018 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, Төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/		
<b>3.1.</b>	<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга</b>	<b>39488,9</b>
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	39488,9
<b>3.2.</b>	<b>Засаг дарга</b>	<b>1143323,3</b>
3.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	1143323,3
3.2.1.1.	<b>Үүнээс: Засаг даргын тамгын газар</b>	<b>187649,8</b>
	Урсгал зардлын дээд хэмжээ	187649,8
	<b>Багийн Засаг дарга</b>	<b>27709,2</b>
	Урсгал зардлын дээд хэмжээ	27709,2
3.2.1.2.	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн дээд хэмжээ	<b>704516,7</b>
	Урсгал зардлын дээд хэмжээ	704516,7
3.2.1.3	<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>	<b>52447,6</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52447,6
	Орон нутгийн төсвөөс	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.4	<b>Сум хөгжүүлэх сан</b>	<b>120000,0</b>
	Үүнээс үйл ажиллагааны зардал	800,0
	Туслах үйл ажиллагааны орлогоос	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.5	<b>Байгаль хамгаалах сан</b>	<b>30000,0</b>
	Орон нутгийн төсвөөс	
	Туслах үйл ажиллагааны орлогоос	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.6	<b>Мал хамгаалах сан</b>	<b>15000,0</b>
	Туслах үйл ажиллагааны орлогоос	
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.7	<b>ИТХ –ын ахмадын сан</b>	<b>999,0</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.8	<b>ЗДТГ–ын ахмадын сан</b>	<b>2450,7</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
3.2.1.9	<b>Сургуулийн ахмадын сан</b>	<b>1813,8</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	
	<b>Цэцэрлэгийн ахмадын сан</b>	<b>386,5</b>
3.2.1.10		
3.2.1.11	<b>Соёлын төвийн ахмадын сан</b>	<b>350,0</b>

**Дөрөв.** Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зарлагын хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

д/д	Төсвийн захирагч	ДҮН /мянган төгрөг/
4.1	Ерөнхий боловсролын сургууль	431410,5
4.2	Хүүхдийн цэцэрлэг	208550,8
4.3	Соёлын төв	64555,4
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>704516,7</b>

**Тав.** Сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 125843,8 мянган төгрөгөөр баталсугай.

**Зургаа.** 2018 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт (барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж)-ын зардлын хэмжээг 52447,6 мянган төгрөгөөр баталсугай.

**Долоо.** Сумын хөрөнгө оруулалт, их засварын нэр төрөл, төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

**Найм.** Төлөвлөгдсөн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлж, зарлагын эх үүсвэрийг ханган, төрийн үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, сумын засаг дарга /Б.Доржсүмбэр/-т даалгасугай.



ДАРГА

Б.ЦЭРЭНМӨНХ

Сумын ИТХ-ын 2017 оны...сарын  
...өдрийн 4 дүгээр хуралдааны  
...дугаар тогтоолын хавсралт

**Сумын төсвийн хөрөнгөөр 2018 оны төсвийн жилд  
хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ,  
барилга байгууламжийн жагсаалт**

(мянган төгрөг)

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	2016 онд санхүүжүүлэх дүн
<b>НИЙТ ДҮН</b>		<b>2018</b>	<b>2018</b>	<b>52447,6</b>	<b>52447,6</b>
Шилжих хөрөнгө оруулалт					
1					
Шинэ хөрөнгө оруулалт					
<b>Хөрөнгө оруулалт</b>					
1					
<b>Их засвар</b>					
1					
<b>Тоног төхөөрөмж</b>		<b>2018</b>	<b>2018</b>	<b>42447,6</b>	<b>42447,6</b>
1	Гүн өрмийн худаг гаргах	2018	2018	15000,0	15000,0
2	Эрчим хүч татах	2018	2018	10000,0	10000,0
3	Дулааны шугамын ажил	2018	2018	7447,6	7447,6
4	Өвс тэжээлийн хашаа барих	2018	2018	10000,0	10000,0
<b>Төсөл арга хэмжээ</b>		<b>2018</b>	<b>2018</b>	<b>10000,0</b>	<b>10000,0</b>
1	Үндэсний их баяр наадмын	2018	2018	5000,0	5000,0
2	Өвс тэжээлийн фонд байгуулах	2018	2018	5000,0	5000,0



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 27

Хажуу шинэ үе

Сумын 2017 оны төсвийн тодотгол  
батлах тухай

Төсвийн тухай хуулийн 64.1.2 дахь заалт, Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 18.1.2 дахь заалт, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 11 сарын 15-ний өдрийн хуралдааны тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Говь Угтаал сумын 2017 оны төсвийн тодотгосон орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

	Сумын төсвийн орлого бүгд	1136911,3
1	Урсгал орлого	47918,9
1.1.	Татварын орлого	30590,0
1.1.1.	Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	11260,7
1.1.2.	Бууны албан татвар	1210,0
1.1.3.	Төсвийн тухай хуулийн 23.4.9-д зааснаас бусад улсын тэмдэгтийн хураамж	2174,0
1.1.4	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	450,0
1.1.5	Хог хаягдлын үйлчилгээ	2695,3
1.1.6	Ан амьтаны нөөц ашигласны төлбөр	12800,0
1.2.	Татварын бус орлого	17328,9
1.2.1	Хадгаламжийн хүүгийн орлого	3368,3
1.2.2	Хүү, торгуулийн орлого	13000,0
1.2.3	Бусад орлого	960,7
3.	Тусламжийн орлого	1088992,4
3.1	Санхүүгийн дэмжлэг	261104,4
3.2	Орон нутгийн хөгжлийн сан орлогын шилжүүлэг	45460,4
3.3	Тусгай зориулалтын шилжүүлэг	595576,3
3.4	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2000,0
3.5	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57175,9
3.6	Урьд оны үлдэгдлээс	127675,4

2.Говь Угтаал сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг дор дурдсанаар баталсугай.

040030



/мянган төгрөг/

2	Засаг дарга	3150,0
2.1.	Засаг даргын тамгын газар	1000,0
2.2	Сургуулийн захирал	150,0
2.3.	Соёлын төв	2000,0

3.Сумын 2017 оны орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсвийн жилд зарцуулах зарлагын дээд хэмжээг дор дурьдсанаар баталсугай.

/мянган төгрөг/

<b>3.1.</b>	<b>Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга</b>	<b>82935,8</b>
3.1.1.	Урсгал зардлын дээд хэмжээ	82935,8
<b>3.2.</b>	<b>Засаг дарга</b>	<b>1053975,5</b>
3.2.1	Урсгал зардлын дээд хэмжээ	1053975,5
3.2.1.1.	<b>Үүнээс: Засаг даргын тамгын газар</b>	<b>214227,9</b>
	Урсгал зардлын дээд хэмжээ	214227,9
3.2.1.2.	Сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй улсын төсөвт байгууллагад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн дээд хэмжээ	<b>597726,3</b>
	Урсгал зардлын дээд хэмжээ	597726,3
3.2.1.3	<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>	<b>62920,0</b>
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45460,4
	Орон нутгийн төсвөөс	6459,6
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11000,0
3.2.1.4	<b>Сум хөгжүүлэх сан</b>	<b>140000,0</b>
	Туслах үйл ажиллагааны орлогоос	43961,7
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	96038,3
3.2.1.5	<b>Байгаль хамгаалах сан</b>	<b>27200,0</b>
	Орон нутгийн төсвөөс	6400,0
	Туслах үйл ажиллагааны орлогоос	8893,4
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	11906,6
3.2.1.6	<b>Мал хамгаалах сан</b>	<b>5510,0</b>
	Туслах үйл ажиллагааны орлогоос	3170,8
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2339,2
3.2.1.7	<b>ИТХ –ын ахмадын сан</b>	<b>1209,0</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1209,0
3.2.1.8	<b>ЗДТГ–ын ахмадын сан</b>	<b>3132,6</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3132,6
3.2.1.9	<b>Сургуулийн ахмадын сан</b>	<b>1623,9</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1623,9
3.2.1.10	<b>Цэцэрлэгийн ахмадын сан</b>	<b>425,8</b>
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	425,8

4.Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжих төсөвт байгууллагын зардлын хэмжээг дор дурдсанаар баталсугай:

		/мянган төгрөг/
4.1.	Дунд сургууль	370523,6
4.2	Хүүхдийн цэцэрлэг	168358,2
4.3	Соёлын төв	58844,5
Дүн		<b>597726,3</b>

5. Говь-Угтаал сумын 2017 оны төсвийн жилд зарцуулах төсвийн зарлагын хэмжээг 1136911,3 мянган төгрөгөөр баталсугай.

6. Төлөвлөгдсөн орлогыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлж, зарлагын эх үүсвэрийг ханган, төрийн үйлчилгээг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч, сумын засаг дарга Б.Доржсүмбэрт даалгасугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 28

Хажуу шинэ үсэг

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.6, 3.3 дугаар зүйлийн 3.3.3 дах заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Б.Доржсүмбэр	/Засаг дарга/
Нарийн бичгийн дарга:	Т.Цэрэнчунт	/ЖДҮХ ажилтан/
Гишүүдэд:	Э.Уранбилэг	/Ерөнхий нягтлан бодогч/
	С.Дугарбаатар	/1-р багийн төлөөлөл/
	Б.Номин-Эрдэнэ	/2-р багийн төлөөлөл/
	Д.Амгалан	/3-р багийн төлөөлөл/
	Т.Энхжаргал	/Банкны төлөөлөл/

2. Суманд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж, сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд хагас жилээр, Төлөөлөгчдийн хуралдаанд бүтэн жилээр тайлагнахыг зөвлөлийн дарга /Б.Доржсүмбэр/-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭРЭНМӨНХ



040031

Сумын ИТХ-ын 2017 оны ...сарын .18  
 өдрийн дөрөвдүгээр хуралдааны  
 д.д...дугаар тогтоолын хавсралт

2018 онд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд баримтлах чиглэл

Д/д	Салбар		Чиглэл
1	Хөдөө аж ахуйн салбар	Малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Сүү,сүүн бүтээгдэхүүн
			Мах махан бүтээгдэхүүн
			Арьс шир боловсруулах ба бүтээгдэхүүн үйлдвэрлэх
			Дайвар ба бусад түүхий эд
2	Газар тариалан	Хүнсний ногоо	Хүлэмжийн аж ахуй
			Хүнсний ногоо
3	Хөнгөн үйлдвэрлэл	Интернет кафе	Зурагчин,компьютерийн бүх төрлийн үйлчилгээ,хэвлэлийн эх бэлтгэх гэх мэт
		Гуталчин	Гутал зан засвар
		Үсчин гоо сайхан	Үсчин гоо сайхан
		Оёдол	Оёдол,хувцас засвар
4	Аялал жуулчлал		Амралтын газар, жуулчны бааз



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 29

Хажуу шинэ үсэг


Газар зохион байгуулалтын 2018 оны  
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын газар зохион байгуулалтын 2018 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Газрын харилцаатай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралд, бүтэн жилээр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг Засаг дарга /Б.Доржсүмбэр/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

040034



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2017 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 30

Хажуу шинэ ус

Тэргүүлэгчдийн 2017 оны үйл  
ажиллагааны тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дах заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны үйл ажиллагааг хангалттай гэж үзсүгэй.

2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхийн хугацаанд баримтлах чиглэлийг жилийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж ажиллахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭРЭНМӨНХ

040036